

## ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН СТАНДАРТЫГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА, ХЭРЭГЛЭЭ

1. Дэлхийн улс орнуудын худалдаа, үйлчилгээний салбарт олон хэв маягийн худалдааны газруудын хөгжил өргөжин тэлж үйлчилгээний цэг салбаруудыг нэгтгэсэн сүлжээ бүтэц улам боловсронгуй болсоор байгаа
2. Худалдаа, үйлчилгээнд төрөл бүрийн автоматчилагдсан техник, тоног төхөөрөмж нэвтэрч үйлчилгээг хялбарчилах болсонтой холбоотой үйлчилгээнд тавигдах шаардлагууд улам детальчилагдаж нарийсч байна.
3. Худалдааны газрын үйлчилгээнд гарч буй дэвшилтэт хандлагатай зэрэгцэн хөгжих шаардлага зүй ёсоор гарч ирж байна. Цаг үе ч үүнийг шаардаж байна. Манай үйлчилгээний зах зээлд олон улсын ая тухтай сүлжээ дэлгүүрийн бүтэц хүч түрэн орж ирж өргөжин тэлж байгаа энэ үед үндэсний худалдаачдынхаа өрсөлдөх чадавхийг хөгжүүлэх үйлчилгээнд өөрийн улс орны онцлогт нийцсэн үндэсний сүлжээний бүтцийг хөгжүүлэх зорилгоор энэхүү стандартад ая тухтай дэлгүүрийн үйлчилгээнд тавигдах шаардлагыг нарийвчлан тусгаж өгөх нь чухал болоод юм. Одоогийн мөрдөж байгаа MNS 5021-1/2019 стандарт нь ерөнхий шаардлагыг тусгасан байдаг учраас шинэ хэв маяг бүхий худалдааны газрын хөгжлийг сааруулах талтай
4. Худалдааны газрын үйлчилгээнд тавигдах шаардлагыг хэв маяг тус бүрийн онцлогийг илэрхийлж ялгааг гаргаж өгвөл практикт ашиглаж мөрдөхөд илүү хялбар байдаг гэсэн мэргэжлийн байгууллагууд болон худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн санал хүсэлт нилээдгүй ирдэг учраас үйлчилгээнд тавигдах ялгаа заагийг нарийвчлан тусгах шаардлагатай болсон
5. Үндэсний худалдаачид олон улсын худалдаа үйлчилгээний хөгжилтэй хөл нийцүүлэн хөгжих хүсэл эрмэлзэлтэй болсон тиймээс шинэ техник, технологийг үйлчилгээндээ нэвтрүүлэх, үйлчилгээг хялбарчилах, ая тухтай орчинг бүрдүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж үйлчилгээний ажилчдынхаа ажлын байрны тогтвортой байдлыг хангаж хүний нөөцөө зохистой ашиглах, өрсөлдөх чадвар бүхий олон хэв маягийн үйлчилгээг нэвтрүүлж хөгжүүлэхэд энэхүү стандартын шинэчлэл чухал.
6. Стандартын шинэчилсэн нэмэлт заалтад худалдааны газрын хүчин чадлын үзүүлэлтийг тодорхойлохдоо бусад улс орны стандартын туршлагаас нилээдгүй судалсан. Үүнд худалдааны газрын хүчин чадлыг талбайн хэмжээнээс хамааруулж үнэлэх нь түгээмэл.  
Мөн ангилал, нэр томъёоны стандартад худалдааны газрын төрөл, хэв маягийг тодорхойлохдоо хүчин чадлын үзүүлэлтийн дээд, доод хэмжээг заадаг бол үйлчилгээнд тавигдах шаардлага үзүүлэлтэд хэв маяг тус бүрийн ялгаа заагийг гаргах шаардлагуудыг стандартчилах нь түгээмэл байна. Тиймээс нэр томъёоны стандартад хүчин чадлын үзүүлэлтийг тодорхойлсон бол үйлчилгээнд тавигдах шаардлагын стандартад дахин тусгах нь оновчтой биш юм. /Ойлголт давхардах/

Зарим улс орнуудын тухайд ялангуяа өндөр хөгжилтэй улс орнуудын худалдааны стандартад худалдааны газрын талбайн доод хэмжээг стандартчилж өргөжин тэлж дараагийн ангилалын хэв маягт дэвшин хөгжих боломжийг илүүтэй харгалзан үздэг туршлага ч байна

7. Аялал жуулчлалын бүс, онгоцны, галт тэрэгний, явуулын зам дагасан кемпүүд, бензин түгээгүүрийн газар, зуслан, амралт, зугаалгын газруудад улирлын шинж чанартай худалдааны цэгүүд илүүтэй ашиглагдах болж үүнээс хамаарч тухайн бүсийн онцлогт нийцсэн суурин биш бага хүчин чадалтай байгууламжуудын олон хэв маяг хөгжиж байна. Тиймээс 30 м.кв түүнээс дээш талбай бүхий худалдаа, үйлчилгээний байгууламжийг стандартчилах шаардлага зайлшгүй гарч байгаа болно. Үүний тод жишээг автобусны буудлын дэргэдэх GS25-ын салбар цэгүүдээс харж болох юм. Мөн цар тахлын үеэр үйлчлүүлэгч, худалдан авагчид томоохон хүчин чадалтай худалдааны газруудыг зорьж очих хандлага багассанаас бага хүчин чадалтай дэлгүүр, цэгүүдийн үйлчилгээ давамгайлах болсныг анхаарах хэрэгтэй.
8. Ковид цар тахлын үед хүргэлтийн болон дэлгүүрийн бус үйлчилгээний олон төрөл, хэлбэрийг ашиглах болж үүнийг дагаж үйлчилгээнд тавигдах шаардлагаууд ч нарийсч уламжлалт үйлчилгээний технологи ч шинэчлэгдэж байна. Ялангуяа автомат ухаалаг техник, тоног төхөөрөмж олноор нэвтэрч үйлчилгээ хялбарчилагдаж байгаагаас худалдааны талбайг үр ашигтай ашиглах боломжийг бүрдүүлэх талаас илүүтэй анхаарч зүйл заалтуудыг тусгасан болно.

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалын код: 03.080.30

Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага	MNS 5021-2:2023
Retail trade and service. General requirements	MNS 5021:2019-ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 20.... оны.... дугаар сарын.....-ний өдрийн .....дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 20.... оны ..... дугаар сарын ..... -ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартыг 20.... оны .....дугаар сарын .....-ний өдрөөс мөрдөнө.

### 1 Хамрах хүрээ

1.1 Энэхүү стандартаар жижиглэн худалдааны газар, түүнд тавих ерөнхий болон нэмэлт шаардлагыг тогтооно.

1.2 Энэ стандарт нь дэлгүүрийн бус жижиглэн худалдааны газарт хамаарахгүй.

### 2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах стандарт, баримт бичгээс эш татсан бөгөөд эдгээрт өөрчлөлт, нэмэлт орсон тохиолдолд албан ёсны материалаас эш татна. Үүнд:  
MNS 6506:2023 *Худалдааны үйлчилгээ. Худалдааны газрын ангилал, нэр томьёо*,  
MNS 5364:2011, *Худалдааны агуулах. Ерөнхий шаардлага*,  
MNS САС РСР 20:2007 *Хүнсний олон улсын худалдаанд баримтлах ёс зүй*,  
MNS САС 1:2003, *Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчмын дадлын олон улсын зөвлөмжийн дүрэм*,  
MNS САС 32:2017, *Органик хүнсийг боловсруулах, үйлдвэрлэх, шошголох, худалдаалахад баримтлах арга зүйн удирдамж*,  
MNS 6648:2016, *Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага*,  
MNS 6777:2019, *Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын нэр томьёо, тодорхойлолт*,  
USC В 1202:2022, *Худалдаа, үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага*,  
MNS 5283:2022, *Гудамж зам талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага*,  
MNS 4990:2000, *Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага*,  
MNS 6767:2019, *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага*,  
MNS 5390:2004, *Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага*,  
MNS 6423:2019, *Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага*,  
MNS 5005:2015, *Төлбөрийн баримт хэвлэх төхөөрөмж*,  
MNS 6529:2015, *Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримт*,  
MNS 5343:2011, *Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэх*,  
MNS 5346:2017, *Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ*.

БНБД 2.03.12-87, *Үйлдвэрийн барилга, байгууламжийн төлөвлөлтийн эрүүл ахуйн норм ба дүрэм*,

### **3 Нэр томъёо, тодорхойлолт**

Энэхүү стандартад заасан нэр томъёо тодорхойлолтыг “MNS 6506:2023, Худалдааны үйлчилгээ. Худалдааны газрын ангилал, нэр томъёо” стандартад зааснаар ойлгоно.

### **4 Ерөнхий шаардлага**

#### **4.1 Барилга, байгууламж, гадаад, дотоод орчинд тавих шаардлага**

**4.1.1** Мэргэжлийн байгууллагын баталсан зураг төслийн дагуу худалдаа, үйлчилгээний зориулалттай баригдсан, улсын комиссын акт, шийдвэрээр ашиглалтад орсон нэмэлт тохижуулалт хийж өргөтгөсөн, шинэчлэсэн тохиолдолд эрх бүхий байгууллага хянаж баталгаажуулсан байна.

ТАЙЛБАР:Хүчин чадлаас хамаарч суурин, суурин бус байгууламж байж болно.

**4.1.2** Ариун цэврийн байгууламж төвлөрсөн системд холбогдоогүй бол цэвэр болон ундны усны хангамж, бохир зайлуулалтыг дэвшилтэт технологиор шийдвэрлэсэн байж болно.

**4.1.3** Төвлөрсөн дулааны системд холбоогүй тохиолдолд халаалтыг цахилгааны болон бусад эх үүсвэр ашиглан эрчим хүчний хэмнэлттэй, агаар, орчны бохирдлыг бууруулах смарт технологиор шийдвэрлэнэ.

**4.1.4** Барилга байгууламжийн төлөвлөлт нь худалдаа, үйлчилгээний технологийн урсгалыг зөв төлөвлөж шийдвэрлэсэн байна.

**4.1.5** Барилга байгууламж нь MNS 6767:2019, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Ажлын байран дах гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөгдөх хэмжээнд тавих ерөнхий шаардлагын хангасан байна.

**4.1.6** Худалдааны газрын гадна талбай “Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах ерөнхий шаардлага UCS 1901 В стандартад нийцсэн, доторх үйлчилгээний танхимын гэрэлтүүлэг 540лк, агуулахад 220лк, хонгил бусад хэсэгт 110 лк-ээс багагүй байна.

**4.1.7** Барилга байгууламж нь “MNS 5078:2001, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага” стандартыг хангасан байна.

**4.1.8** Худалдаа үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага UCS 1201В:2022, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин MNS 6055 стандартын шаардлагын дагуу төлөвлөнө.

**4.1.9** Худалдаа, үйлчилгээний газрын хаяг нь MNS 5283:2022, Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгө, аж ахуйн нэгж байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий

шаардагыг хангана.

**4.1.10** Хяналтын камер нь “MNS 6423:2019, Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага” стандартад нийцсэн байна.

**4.1.11** Худалдааны газрын хүчин чадлаас хамаарч ногоон байгууламж, автомашины зогсоолын талбайг төлөвлөнө.

**4.1.12** Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээллийн самбарыг байршуулж, гэрэлтүүлгээр тоногдсон байж болно.

**4.1.13** Хог хаягдлыг ангилан ялгаж хаях хогийн савыг орох, гарах хэсэгт байрлуулна.

**4.1.14** Бараа хүлээн авах, буулгах тавцан, тэмдэглэгээ бүхий цардсан зам, талбайтай байна.

## **4.2 Худалдааны газрын талбайн төлөвлөлтөд тавих шаардлага**

**4.2.1** Худалдааны газрын дотоод орчин, ажлын байр талбай нь технологийн урсгал дагуу төлөвлөгдсөн байна.

**4.2.2** Худалдааны танхимын нэвтрэх бүсэд орох, гарах урсгалыг зохицуулсан чиглүүлэгч тэмдэг, тэмдэглэгээг байршуулна.

**4.2.3** Тасгуудын байршлыг мэдээлэх хаягжуулалтыг хийнэ.

**4.2.4** Худалдааны газрын хүчин чадалд нийцүүлэн түргэн хоол үйлчилгээний хэсэг байж болно.

ТАЙЛБАР: Ая тухтай дэлгүүрийн шаардлагад хамаарна.

**4.2.5** Худалдааны танхимын нэвтрэх бүсийн дагуу тээш хадгалах хэсгийг төлөвлөнө.

**4.2.6** Худалдааны танхимын гарах урсгал дагуу тооцооны хэсэгт кассын машин болон ухаалаг автоматыг байршуулсан байна.

**4.2.7** Худалдааны газрын хүчин чадалд нийцүүлэн бараа хадгалах агуулахыг төлөвлөх ба MNS 5364:2011 Худалдааны агуулах ерөнхий шаардлагад нийцсэн байна.

ТАЙЛБАР: Бага хүчин чадалтай дэлгүүрт хамаарахгүй байж болно.

**4.2.8** Баяр ёслолын болон урамшуулалт худалдаа, сурталчилгааг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн тохижуулсан худалдааны газрын гадна орчны талбайд зохион байгуулна.

**4.2.9** Хүнсний бүтээгдэхүүнийг жижиглэн савлах, ангилах, ялгах, багцлах, барааг худалдаанд бэлтгэх өрөөтэй байна.

ТАЙЛБАР: Бага, багавтар хүчин чадалтай дэлгүүрт хамаарахгүй байж болно.

**4.2.10** Үйлчлүүлэгч, ажиллагсдад зориулсан ариун цэврийн өрөөтэй байх, хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөөг хүчин чадалдаа

тохируулж төлөвлөнө.

ТАЙЛБАР: Бага болон багавтар хүчин чадалтай дэлгүүрт хамаарахгүй байж болно.

**4.2.11** Болзошгүй аюул, ослын үед орох, гарах гарцын бүдүүвч зураг, мэдээллийн самбарыг ил тод харагдах хэсэгт байршуулна.

### **4.3 Хүнсний худалдааны тоног төхөөрөмжид тавих шаардлага**

**4.3.1** Барааг ачих буулгах, зөөвөрлөх, худалдаанд бэлтгэх, жижиглэн савлах зориулалтын төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байна.

**4.3.2** Орчны чийг, температур хэмжигч багажийг тодорхой хэсэгт байршуулан хэмжилтийг тогтмол хянаж бүртгэл хөтөлнө.

**4.3.3** Барааг өрж байршуулах зориулалтын лангуу, тавиур, тавцан, бусад хэрэгслээр тоноглогдсон байна.

**4.3.4** Барааг өрж байрлуулах ханын тавиурын өндрийн хэмжээ 180 см-ээс ихгүй, шалнаас 20 см-с багагүй зайд хөндийрүүлсэн байна.

**4.3.5** Худалдааны газрын хүчин чадлаас хамаарч лангуу, тавиурын хоорондын зай 1-1,5 метрээс дээш хэмжээтэй байна.

**4.3.6** NNS 5005:2015, Татварын нэгдсэн системд холбогдон ажиллах төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлагыг хангасан төлбөрийн баримтыг хэвлэх төхөөрөмжтэй байна.

**4.3.7** Температурын тохируулга бүхий хөргөх, хөлдөөх төхөөрөмжтэй байна. Хэвийн үйл ажиллагааг нь хянаж тогтмол бүртгэл хөтөлнө.

**4.3.8** Ундаа, цэвэр усны хөргөгчийн арын хэсэг нь нөөцийн өрөөтэй шууд холбогдсон, хөргөгчийн арын хэсгээс сэлбэлтийг тогтмол хийнэ.

ТАЙЛБАР: Ая тухтай дэлгүүрийн шаардлагад хамаарна.

**4.3.9** Хяналтын жин хэмжүүрийг шаардлагатай хэсэгт байршуулна.

**4.3.10** Халуун, хүйтэн ундаа, уух шингэн зүйлийг худалдаалах автомат машиныг үйлчилгээний танхимд байршуулж худалдан авагч өөртөө үйлчлэх боломжийг бүрдүүлнэ. Худалдааны ажилтан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлнэ.

ТАЙЛБАР: Ая тухтай дэлгүүрийн шаардлагад хамаарна.

**4.3.11** Техник, технологийн нарийн горим бүхий ажиллагаатай халуун баригч автомат тоног төхөөрөмжид халуунаар шууд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн, хоол, зуушийг технологийн дагуу хадгалж худалдаална.

ТАЙЛБАР: Ая тухтай дэлгүүрийн шаардлагад хамаарна.

### **4.4 Худалдааны газрын технологид тавих шаардлага**

**4.4.1** Хүнсний бараа худалдаалах ажиллагаанд эрүүл ахуйн зохистой дадлыг мөрдөнө.

**4.4.2** Бараа бүтээгдэхүүн эрүүл ахуйн шаардлага, аюулгүйн үзүүлэлтийг хангасан эсэхэд хяналт тавьж хаяг шошгоны зөрчил, хуурамч бүтээгдэхүүнийг бүртгэж холбогдох байгууллагад тухай бүр мэдээлнэ.

**4.4.3** Барааг хэрэглэх, ашиглах зөвлөгөө өгч, бүрэн бүтэн байдлыг шалгаж, аюулгүй ажиллагааны санамж, баталгаат хугацааны хуудсыг дагалдуулж олгоно.

**4.4.4** Худалдааны талбайд тасгуудыг харилцан уялдаатай оновчтой төлөвлөж байршуулсан байна.

**4.4.5** Худалдааны газрын төрөлжилттэй нийцүүлэн барааны нэр төрлийн бүрдүүлэлтийг хийнэ.

**4.4.6** Барааг бүлэг, дэд бүлгээр төрөлжүүлэн ангилж, өрөлтийн арга технологийн дагуу лангуу, тавиур, төхөөрөмжид байршуулна.

**4.4.7** Органик эрүүл мэндийг дэмжих, хүүхдэд зориулсан, хоолны тусгай дэглэмтэй хүнд зориулсан бүтээгдэхүүний тусгай тасагтай байж болно.

**4.4.8** Тод гаргацтай бичсэн барааны нэгжийн үнийн хаягийг нэр төрөл тус бүрт байршуулсан байна.

**4.4.9** Ахуйн химийн барааг хүнсний барааны чанарт нөлөөлөхгүй тусгай лангуу, тавиурт байршуулж худалдаална.

**4.4.10** Бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээний дүгнэлтийн баримтыг шаардлагатай тохиолдолд цахим буюу цаасан хэлбэрээр мэдээлж болно.

**4.4.11** MNS 6648:2016, Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошгололтод тавих шаардлагыг хангасан барааг хүлээн авч худалдана.

**4.4.12** MNS 5343:2011, Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэх стандартын шаардлагын дагуу хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэнэ.

**4.4.13** Худалдааны газар нь дотоод хяналтын журмыг боловсруулж мөрдөж ажиллах ба холбогдох бүртгэлийг хөтөлсөн байна.

**4.4.14** Худалдан авсан бараа бүтээгдэхүүний төлбөр тооцоог үнэн зөв гүйцэтгэж төлбөрийн баримт олгох, барааг савлах гардуулах үйлчилгээг үзүүлнэ.

**4.4.15** Худалдан авсан бараанд бүтээгдэхүүний нэр төрөл, онцлог шинжээс хамаарч чанарын баталгаа гаргаж үйлчилнэ.

**4.4.16** Худалдан авагчдад үйлчилгээг хөнгөвчлөх төрөл бүрийн нэмэлт үйлчилгээг үзүүлнэ.

ТАЙЛБАР: Жагсаалтад заагдсан нэмэлт үйлчилгээнээс сонгоно.

**4.4.17** Худалдан авагч өөртөө үйлчлэх зориулалт бүхий богино долгионы зуух, цахилгааны залгуур, интернет сүлжээ /WiFi/, ус буцалгагч зэрэг хэрэгслүүдийг

үйлчилгээний танхимд байршуулах ба аюулгүй ажиллагааны зааварчилгааг хэвлэж байршуулсан байна.

ТАЙЛБАР: Ая тухтай дэлгүүрийн шаардлагад хамаарна.

**4.4.18** Хэрэглэгчийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх ажилтантай байна.

**4.4.19** Бараа буцаах, санал гомдол хүлээн авах хэрэглэгчийн үйлчилгээний төвийг ажиллуулж холбогдох дүрэм журмыг ил тод мэдээлж байна.

**4.4.20** Орох хаалганы гадна хэсэгт үйлчилгээний цагийн хуваарийг үйлчлүүлэгчдэд харагдахуйцаар байршуулсан байна.

#### **4.5 Ажлын байрны эрүүл ахуйд тавих шаардлага**

**4.5.1** Худалдааны ажилтан нь автомат тоног төхөөрөмжийг ашиглах цахилгаан техникийн анхан шатны мэдлэгтэй, ашиглалтын явцад гарсан жижиг гэмтэлд засвар үйлчилгээ хийх чадвартай байна.

ТАЙЛБАР: Ая тухтай дэлгүүрийн шаардлагад хамаарна.

**4.5.2** Худалдааны газар нь байгалийн, механик болон автомат агааржуулалтын системийг ашиглана.

**4.5.3** Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөнө.

**4.5.4** Хүнсний түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнийг зориулалтын хөргөх, хөлдөөх тоног төхөөрөмжид тус тусад нь ангилж хадгалж худалдаална.

**4.5.5** Худалдааны багаж хэрэгслүүд /хутга, хайч, хавчаар, хутгуур, жин, түрдэг тэрэг, сагс г.м/-ийг зааврын дагуу тогтмол угааж, халдваргүйжүүлнэ.

**4.5.6** Ариутгал, халдваргүйтгэл, хортон шавьж, мэрэгч устгалыг тогтсон хугацаанд мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байна.

**4.5.7** Техник, тоног төхөөрөмж бүр ашиглалтын гэрчилгээтэй, засвар үйлчилгээ хийсэн бүртгэл хөтөлнө.

#### **4.6 Галын аюулгүй байдалд тавих шаардлага**

**4.6.1** Худалдааны газрын барилга байгууламж нь галд тэсвэршилтийн I-IV зэрэглэлтэй, галын аюулгүйн дүрэмд тавигдах шаардлагыг хангасан байх Барилга байгууламжийн галын аюулгүйн дүрэмд тавих шаардлагыг хангасан байна.

**4.6.2** Худалдааны газар нь MNS 5390:2004, Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлагыг хангасан байна.

**4.6.3** Техник, тоног төхөөрөмж, цахилгааны монтажийг галын аюулгүйн болон техник ашиглалтын дүрмийн дагуу угсарсан байна.



#### **4.7 Худалдааны ажилтны ур чадвар, мэдлэг, боловсролд тавих шаардлага**

**4.7.1** Худалдааны зөвлөх, худалдагч, борлуулагч нь мэргэжлийн үнэмлэхтэй, гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байна.

**4.7.2** Жолооч, түгээгч, агуулахын ажилтан, бараа ачигч, буулгагч нь мэргэжлийн сургалтад хамрагдсан байна.

**4.7.3** Худалдааны газрын гэрээт ажилтан буюу цагийн ажилтан нь мэргэжлийн сургалтад хамрагдсан байна.

**4.7.4** Худалдааны ажилтны ур чадварын түвшинг I-III зэрэг дэвтэй байхаар үнэлж болно.

**4.7.5** Худалдаа, үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг судалж, мөрдөж ажиллана.

**4.7.6** Худалдааны ажилчдыг тогтмол мэдээллээр хангах мэдээллийн сан бүрдүүлсэн байна.

#### **4.8 Ажиллагсдын эрүүл ахуй, аюулгүй байдалд тавих шаардлага**

**4.8.1** Хүнсний сүлжээнд ажиллагсад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд тогтоосон хугацаанд хамрагдсан байна.

**4.8.2** Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, худалдах, түүгээр үйлчилгээ үзүүлэх, хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтан нь эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байна.

**4.8.3** Худалдааны ажилтан нь лого, энгэрийн тэмдэг бүхий ажлын дүрэмт хувцсыг өмсөнө.

### **5 Нэмэлт үйлчилгээ**

Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх нэмэлт үйлчилгээний янз бүрийн төрөл хэлбэрийг ашиглаж болно.

- Илгээмжийн үйлчилгээ
- Хүргэлтийн үйлчилгээ
- Төлбөр тооцоо /АТМ/
- Шуудан холбоо
- Автобусны карт цэнэглэх
- Фото зураг хэвлэх
- Канон үйлчилгээ
- Үзвэрийн билетийн захиалга авах
- Төрийн үйлчилгээний цэг /ТҮЦ машин/
- Каталогийн үйлчилгээ
- Цахимаар барааны захиалга авах
- Бэлгийн багцын үйлчилгээ
- Барааны амталгаа, үзүүлэн сурталчилгаа

- Хүүхдийн булан ажиллуулах
- Цахим дэлгэцээр сурталчилгаа, мэдээлэл өгөх
- Урамшуулал, хөнгөлөлтийн карт
- Таксины дуудлагын үйлчилгээ
- Мэргэжлийн мэргэжилтний зөвлөх үйлчилгээ
- Цэцэг, ном, хэвлэл, ил захидлын үйлчилгээ
- Бэлэг, дурсгалын зүйл дээр үг бичих
- Өөртөө үйлчлэх ахуйн үйлчилгээний цэг

## **6 Жижиглэн худалдааны газрын төрөл, онцлогт тавих шаардлага**

**6.1** Жижиглэн худалдааны газрын төрлөөс хамаарч тавих шаардлагыг нарийвчлан тодорхойлж 1 дүгээр хүснэгтэд тусгав.

1-р хүснэгт – Жижижглэн худалдааны газарт тавих шаардлага

№	Худалдааны газрын ангилал		Их дэлгүүр	Молл	Хайпермаркет	Супермаркет	Минимаркет	Ая тухтай дэлгүүр	Хүнсний дэлгүүр	Мухлаг	Хүнсний бус	Бөөний худалдаа	
1	Барилга байгууламж, гадна орчны төлөвлөлтөд тавигдах шаардлага												
1.1	Барилга байгууламж	Мэргэжлийн байгууллагын баталсан зураг төслийн дагуу худалдаа, үйлчилгээний зориулалттай баригдсан, улсын комиссын акт, шийдвэрээр ашиглалтад орсон байх.	+	+	+	+	+	+	+	+	+	+	
		Баригдсан барилга байгууламжид нэмэлт өөрчлөлт хийсэн, өргөтгөсөн, шинэчилсэн, засварласан тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр худалдаа үйлчилгээний технологийн урсгалыг хангасан байдлаар өөрчлөлт хийсэн байх.	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Нийтийн орон сууцанд байрлалтай бол гадна хаалга нь орчны хаалганаас тусдаа, орох гарах гарцтай байх.	+	+	+	+	+	±	±	±	-	-	-
		Ариун цэврийн байгууламж төвлөрсөн системд холбогдоогүй бол цэвэр болон ундны усны хангамж, бохир зайлуулалтыг дэвшилтэт технологиор шийдвэрлэсэн байх	+	+	+	+	-	+	-	-	+	+	+
		Төвлөрсөн дулааны системд холбогдоогүй тохиолдолд агаар, орчны бохирдлыг бууруулах байгаль орчинд ээлтэй смарт технологиор дулаанаа шийдвэрлэсэн байх	+	+	+	+	-	+	-	-	+	+	+
1.2	Гадна орчны төлөвлөлт	Гадна орчны орц, гарц, талбайн төлөвлөлтийг худалдаа үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага UCS 1201B:2022, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин MNS 6055 стандартын шаардлагын дагуу хийсэн байх	+	+	+	+	-	±	±	±	+	+	
		Хаяг нь Худалдаа үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага UCS 1202B:2022 стандартад нийцсэн байх	+	+	+	+	-	+	-	-	+	+	+
		Гадна талбайн гэрэлтүүлэг “Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах ерөнхий шаардлага UCS1901B стандартад нийцсэн байх	+	+	+	+	+	+	±	-	+	+	+

		Реклам, сурталчилгааны самбар нь худалдаа үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага UCS 1202B:2022 стандартад нийцсэн байх	+	+	+	+	+	+	±	-	+	+	
		Камертай байх, Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага MNS6423:2019 стандартын шаардлагыг хангасан байх.	+	+	+	+	+	+	±	-	+	+	
1.3	Гадна талбайн зохион байгуулалт	Хог хаягдлыг ангилан ялгаж хаях хогийн савыг орох, гарах хаалганы дэргэд байрлуулсан байх	+	+	+	+	+	+	+	+	+	+	
		Бараа хүлээн авах, буулгах, ачих тавцан, тэмдэглэгээ бүхий цардсан зам, талбайтай байх	+	+	+	+	±	±	-	-	+	+	
		Худалдаа, үйлчилгээний газрын хүчин чадалд тохирсон тээврийн хэрэгслийн хатуу хучилттай зогсоолтой /MNS5342:2007 стандарт, БНБД 32-04-06 норм дүрэм/, зогсоолын орц гарц дээр аюулгүй байдлыг хангах зорилгоор хурд сааруулагч хийсэн байх	+	+	+	±	-	-	-	-	-	+	+
		Хүчин чадлаас хамаарч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон дугуйн зогсоолыг давхар төлөвлөсөн байх	+	+	+	±	±	±	±	-	-	+	+
		Барилга байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих, үйлчлүүлэх хэрэгцээг хангахаар төлөвлөгдөж, тэргэнцэрийн зориулалтын замтай, барилгын гол хаалга, довжоог "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин" MNS6055 стандартад нийцүүлэн зохион байгуулсан байх	+	+	+	±	±	±	±	-	-	+	+
		Худалдаа үйлчилгээний гадна талбай ногоон байгууламжтай, тухайн орчныхоо барилгын архитектур дизайны онцлогт нийцэлтэй тоног төхөөрөмж, гал унтраах багаж хэрэгсэл, хог хаягдлын болон тамхи татах цэгийг байршуулсан байх	+	+	+	±	±	±	±	-	+	+	
2	Дотоод орчны төлөвлөлт, зохион гбайгуулалтад тавигдах шаардлага												
2.1	Дотоод орчны төлөвлөлт	Худалдааны газрын хүчин чадлын үзүүлэлтийг нийт талбайн хэмжээгээр тооцох /M2 дээш нийслэл, хот суурин газар/ ТАЙЛБАР: Эмнэлэг, шатахуун түгээгүүр, нисэх онгоцны буудал, галт тэрэгний, автобусны буудал гэх мэт онцгой бүсүүдэд 30 м2 дээш ая тухтай дэлгүүрийн цэг байрлаж болно.	1000	1000	1000	500	100	40	100	30	100	500	
		Худалдааны газрын хүчин чадлын үзүүлэлтийг нийт талбайн хэмжээгээр тооцох /M2 дээш хөдөө, сум орон нутагт/	1000	1000	1000	300	50	40	100	30	100	300	

		Худалдааны газрын дотоод орчин, үйлчилгээний талбайн төлөвлөлтийг технологийн урсгал дагуу, тасгуудыг харилцан уялдаатай оновчтой төлөвлөж байршуулах	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Худалдааны газрын доторх үйлчилгээний танхимын гэрэлтүүлэг 540 лк, агуулахад 220 лк, хонгил бусад хэсэгт 110 лк-ээс багагүй байх	+	+	+	±	±	±	±	-	+	+	+
		Агааржуулалт нь MNS 4990:2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх	+	+	+	±	±	±	±	-	+	+	+
		Худалдааны танхимын нэвтрэх бүсэд орох, гарах урсгалыг зохицуулсан чиглүүлэгчийг байршуулсан байх	+	+	+	+	-	-	-	-	+	+	+
		Тасгуудын байршлыг мэдээлэх хаягжуулалтыг хийсэн байх	+	+	+	+	-	-	-	-	+	+	+
		Танхимд түргэн хоол үйлчилгээний хэсэгтэй байж болно	±	±	±	±	±	+	-	-	-	-	-
		Худалдааны танхимын нэвтрэх бүсийн дагуу тээш хадгалах хэсгийг төлөвлөнө.	+	+	+	-	-	-	-	-	+	+	+
		Худалдааны танхимын гарах урсгал дагуу тооцооны хэсгийг (касс, автомат төхөөрөмж) төлөвлөж байршуулсан байх.	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Худалдааны газрын хүчин чадлаас хамаарсан агуулахтай байх /MNS 5364;2011 Худалдааны агуулах ерөнхий шаардлага стандарт/	±	±	±	±	±	±	±	-	-	-	-
		Бараа, бүтээгдэхүүнийг худалдаанд /жижиглэн савлах, ангилах, ялгах, багцлах/ бэлтгэх өрөөтэй байна.	+	+	+	+	-	-	-	-	-	-	-
		Үйлчлүүлэгчдэд зориулсан ариун цэврийн өрөөтэй байх, хүүхэд, хөхүүл ээж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тохижилттой, гар угаах хэрэгслээр тоноглогдсон байх	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
2.2	Зохион байгуулалт	Худалдааны газрын талбайн бүдүүвч зураг, бараа үйлчилгээний мэдээллийн самбар, болзошгүй аюул ослын үеийн гарцын мэдээллийг хүний нүдэнд харагдах хэсэгт байршуулсан байх.	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Дотоод хяналтын журамтай, хүчин чадлаас хамаарч дотоод хяналтын орон тооны ажилтантай байх, дотооддоо хяналттай байх	+	+	+	+	-	-	-	-	+	+	+
		Барааг өрж байрлуулах ханын тавиурын өндрийн хэмжээ 180 см-ээс ихгүй, шалнаас 20 см-с багагүй зайд хөндийрүүлсэн байдлаар байршуулсан байх	+	+	+	+	+	+	+	+	+	-	-

		Худалдааны газрын хүчин чадлаас хамаарч лангуу, тавиурын хоорондын зай 1-1.5 метрээс доошгүй хэмжээтэй байрлуулсан байх	+	+	+	+	+	+	+	+	+	-	-	
3	Тоног төхөөрөмж	Худалдан авагчийн зориулалттай барааны сагс, тэргэнцэрийг байршуулсан байх	+	+	+	+	+	+	+	+	+	±	±	
		Технологийн нарийн горим бүхий ажиллагаатай, халуунаар шууд хэрэглэх хүнс, хоол, зуушийг хадгалж худалдаалах зориулалттай халуун баригчтай автомат тоног төхөөрөмжтэй байх	-	-	-	-	-	+	-	-	-	-	-	-
		Төлбөр, тооцооны төхөөрөмжтэй байх	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Температурын тохируулга бүхий хөргөх, гүн хөлдөөх төхөөрөмжтэй байх	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	-
		Ундаа, цэвэр усны хөргөгчийн арын хэсэг нь нөөцийн өрөөтэй шууд холбогдсон байх	-	-	-	-	-	+	-	-	-	-	-	-
		Хяналтын жин хэмжүүрийг шаардлагатай хэсэгт байршуулах	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	-
		Барааг байршуулах зориулалтын лангуу, тавиур, тавцан, өлгүүр гэх мэт төхөөрөмжтэй байх.	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	-
Халуун, хүйтэн ундаа, уух шингэн зүйлийг худалдаалах автомат машиныг үйлчилгээний танхимд байршуулах	±	±	±	±	-	+	-	-	±	±	±	±		
4	Технологи ажиллагаа	Худалдааны газрын төрөлжилттэй нийцүүлэн барааны нэр төрлийн бүрдүүлэлтийг хийнэ.	+	+	+	+	+	+	+	+	+	-	-	
		Барааг бүлэг, дэд бүлгээр төрөлжүүлэн ангилж, өрөлтийн арга технологийн дагуу лангуу, тавиур, зориулалтын төхөөрөмжид байршуулж, бүртгэл хөтлөлт хийдэг байх	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	-
		Органик эрүүл мэндийг дэмжих, хүүхдэд зориулсан, хоолны тусгай дэглэмтэй хүнд зориулсан бүтээгдэхүүний тусгай тасагтай байх, горимын дагуу хадгалж худалаалах нөхцөлийг бүрдүүлсэн байх	+	+	+	+	±	±	-	-	-	-	-	-
		Ахуйн химийн барааг хүнсний барааны чанарт нөлөөлөхгүй тусгай лангуу, тавиурт байршуулах	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан түүхий эд, бараа бүтээгдэхүүн хүлээн авч, худалдаалах	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Худалдааны ажилтан нь автомат тоног төхөөрөмжийг ашиглах цахилгаан техникийн анхан шатны мэдлэгтэй, ашиглалтын явцад гарсан жижиг гэмтэлд засвар үйлчилгээ хийх чадвартай байна.	-	-	-	-	-	+	-	-	-	-	-	-

		Техник, тоног төхөөрөмж бүр ашиглалтын гэрчилгээтэй, засвар үйлчилгээ хийсэн бүртгэл хөтөлнө.	-	-	-	-	-	+	-	-	-	-	
5	Ажлын байр, ажиллагсад тавих эрүүл ахуйн шаардлага	Барааны онцлог шинж чанарт тохируулан горимын дагуу хадгалж, худалдаалах	+	+	+	+	+	+	+	+	+	+	
		Худалдааны багаж хэрэгслүүд /хутга, хайч, хавчаар, хутгуур, жин, түрдэг тэрэг, сагс г.м/-ийг зааврын дагуу тогтмол угааж, халдваргүйжүүлэх	+	+	+	+	+	+	+	+	+	-	-
		Ариутгал, халдваргүйтгэл, хортон шавьж, мэрэгч устгалыг тогтоосон хугацаанд мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байх	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Хүнсний сүлжээнд ажиллагсад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд тогтоосон хугацаанд хамрагдсан байх	+	+	+	+	+	+	+	+	+	-	-
		Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, худалдах, түүгээр үйлчилгээ үзүүлэх, хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтан нь эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх	+	+	+	+	+	+	+	+	+	-	-
		Худалдааны ажилтан нь лого, энгэрийн тэмдэг бүхий ажлын дүрэмт хувцсыг өмсөнө.	+	+	+	+	+	+	+	+	+	+	
6	Галын аюулгүй байдалд тавих шаардлага	Барилга байгууламжийн галын аюулгүйн дүрэмд тавигдах шаардлагыг хангасан, хамгаалалтын систем дохиололтой, гал унтраах багаж хэрэгсэлтэй	+	+	+	+	+	+	+	+	+	+	
		Худалдааны газар нь MNS 5390:2004, Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлагыг хангасан байх	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Техник, тоног төхөөрөмж, цахилгааны монтажийг галын аюулгүйн болон техник ашиглалтын дүрмийн дагуу угсарсан байна	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
7	Хүний нөөц	Худалдааны зөвлөх, худалдагч, борлуулагч нь мэргэжлийн үнэмлэхтэй, гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байна.	+	+	+	±	±	±	-	-	+	+	
		Жолооч, түгээгч, агуулахын ажилтан, бараа ачигч, буулгагч нь мэргэшүүлэх түр сургалтад хамрагдсан байна.	+	+	+	+	+	+	+	+	+	-	-
		Худалдааны газрын гэрээт ажилтан буюу цагийн ажилтан нь мэргэшүүлэх түр сургалтад хамрагдсан байна.	+	+	+	+	+	+	+	+	+	-	-
		Худалдаа, үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын талаар тодорхой мэдлэгтэй байх /тодорхой хугацаанд мэргэжлийн сургалтуудад хамруулдаг байх/	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
8	Нэмэлт үйлчилгээ	Илгээмжийн үйлчилгээ	±	±	±	±	±	±	±	±	±	±	
		Хүргэлтийн үйлчилгээ	±	±	±	±	±	±	±	±	±	±	
		Төлбөр тооцоо /АТМ/	±	±	±	±	±	±	±	±	±	±	

Шуудан холбоо	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Автобусны карт цэнэглэх - Фото зураг хэвлэх - Канон үйлчилгээ - Үзвэрийн билетийн захиалга авах	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Төрийн үйлчилгээний цэг /ТҮЦ машин/	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Каталогийн үйлчилгээ	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Цахимаар барааны захиалга авах	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Бэлгийн багцын үйлчилгээ	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Барааны амталгаа, үзүүлэн сурталчилгаа	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Хүүхдийн булан ажиллуулах	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Цахим дэлгэцээр сурталчилгаа, мэдээлэл өгөх	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Урамшуулал, хөнгөлөлтийн карт	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Таксины дуудлагын үйлчилгээ	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Мэргэжлийн мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Цэцэг, ном, хэвлэл, ил захидлын үйлчилгээ	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Бэлэг, дурсгалын зүйл дээр үг бичих	±	±	±	±	±	±	±	±	±	±	±
Өөртөө үйлчлэх ахуйн үйлчилгээний цэг	±	±	±	±	±	±	±	±	±	±	±

**ТӨГСӨВ.**

**Ном зүй**

ГОСТ Р 51773-2009, Услуги торговли, Классификация предприятий,